

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2024/13/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2024 он</p>	<p>Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас:261663 Цахим хаяг:Naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: Ц.Хосжаргал Утас:260512 Цахим хаяг: Khosjargalts@audit.gov.mn Ахлах аудитор: В.Эрдэнэцогт Утас: 262071 Цахим хаяг:Erdenetsogv@audit.gov.mn Аудитор: М.Пагамдулам Утас:262071 Цахим хаяг:Pagamdulamm@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.02.23 № 07/293

танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эм эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь бидний тогтоосон 45,684.3 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс өндөр байна. Үүнд:

- Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа харьцуулалтын аргаас зайлсхийж 62,830.1 мянган төгрөгийн эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийг шууд худалдан авсан;
- Байгууллагын албан хаагчдад олгосон урамшууллаас 25,440.0 мянган төгрөгийн НДШ, 9,381.0 мянган төгрөгийн ХХОАТ суутган тооцоогүй;
- үйл ажиллагааны урсгал зардлын ангиллыг зөрчиж 180,461.8 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан

зэрэг зөрчил нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5; Төрийн өмчийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, 8.5; ХХОАТ-ын тухай хуулийн 6.3.1; Нийгмийн даатгалын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1; Хөдөлмөрийн тухай хуулийн 83.5 гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэлийн шалгуур үзүүлэлтийн болон тусгай зөвшөөрлийн баримт бичгийн шалгуурыг хангаж эмнэлгийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй 14 нэр төрлийн 25 хэмжлийн тоног төхөөрөмжийг олон улсын хэмжилтийн байгууллага болох Fluke Calibration, BC Biomedical International байгууллагаар 76,500.0 мянган төгрөгөөр хэмжилтийн баталгаажилт хийлгэж, шалгалт тохируулгын гэрчилгээг авсан байна.

Аудитын гол асуудал

Эм эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын даргын тушаалаар ажлын хэсэг байгуулж өөрийн байгууллагын эрхлэх асуудлын хүрээнд хүчин төгөлдөр үйлчилж байгаа захиргааны хэм хэмжээний актуудад хяналт шинжилгээ-үнэлгээ хийж, бусад хууль тогтоомжтой нийцээгүй, уялдааг хангаагүй, утга санаа давхардсан заалтууд болон улсын нэгдсэн санд бүртгээгүй заавар, журмууд байгааг илрүүлж, цаашид авах арга хэмжээний талаар 7 санал, зөвлөмж гаргасан байна.

Эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц, хангамж, тасалдлын мэдээлэл нэгтгэх программыг 2020 онд Ковид-19 цар тахлын дэгдэлтийн үед Интерактив ХХК нийгмийн хариуцлагын хүрээнд үнэ төлбөргүй хийж, Эрүүл мэндийн яаманд хүлээлгэн өгсөн байна. Тус компани нь 2022 оноос хөгжүүлэлт, сайжруулалт хийх талаар гэрээ байгуулж ажиллах санал тавьсныг хүлээж аваагүй тул өнөөдөр Монгол улсын хэмжээнд эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц, хэрэгцээ, хангалтын талаар үнэн зөв, бүртгэл судалгааг гаргах боломжгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Эм эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 12 зорилт 81 арга хэмжээг төлөвлөж, 92.9 хувийн биелэлттэй дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	260,548,908.63	322,301,968.23
33	АВЛАГА	12,665,300.00	83,737,570.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	12,665,300.00	70,000,000.00
33500	Бусад авлага	-	13,737,570.00
33510	Байгууллагаас авах авлага	-	13,737,570.00
35	БАРАА МАТЕРИАЛ	247,883,608.63	238,564,398.23
35100	Түүхий эд материал	160,091,492.40	132,671,742.40
35130	Эм боох материал	160,091,492.40	132,671,742.40
35400	Хангамжийн материал	87,792,116.23	105,148,283.03
35410	Бичиг хэргийн материал	33,083,658.50	43,932,149.50
35420	Аж ахуйн материал	5,587,000.00	3,035,400.00
35440	Түлш, шатах тослох материал	7,410,000.00	8,900,000.00
35470	Бусад хангамжийн материал	41,711,457.73	49,280,733.53
35600	Мал амьтад	-	744,372.80
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,343,763,758.64	1,162,294,752.64
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,343,763,758.64	1,162,294,752.64
39200	Биет хөрөнгө	1,316,325,702.94	1,142,359,696.94
39203	Авто-тээврийн хэрэгсэл	31,500,000.00	15,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(8,925,000.00)	(416,666.67)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	3,118,709,294.22	1,619,960,999.69
39206	Хуримтлагдсан элэгдэл	(2,140,124,677.17)	(758,597,195.93)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	372,986,350.37	365,826,695.32
39208	Хуримтлагдсан элэгдэл	(57,820,264.48)	(99,414,135.47)
39300	Биет бус хөрөнгө	27,438,055.70	19,935,055.70
39301	Програм хангамж	54,070,000.00	54,070,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(26,631,944.30)	(34,134,944.30)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,604,312,667.27	1,484,596,720.87
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	175,350,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	175,350,000.00
41400	Урьдчилж орсон орлого	-	175,350,000.00
41420	Төлбөртэй ажил үйлчилгээний урьдчилж орсон орлого	-	175,350,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,604,312,667.27	1,309,246,720.87
51	Засгийн газрын хувь оролцоо	1,604,312,667.27	1,309,246,720.87
51200	Хуримтлагдсан үр дүн	1,604,312,667.27	1,309,246,720.87
51210	Өмнөх үеийн үр дүн	998,650,312.74	1,604,312,667.27
51220	Тайлант үеийн үр дүн	605,662,354.53	(295,065,946.40)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,604,312,667.27	1,484,596,720.87

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	5,176,869,765.31	5,150,800,968.69
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,046,459,089.31	1,638,970,513.69
120	Нийтлэг татварын бус орлого	2,046,459,089.31	1,638,970,513.69
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,260,530,900.92	1,352,761,575.90
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,260,530,900.92	1,352,761,575.90
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	708,115,912.26	276,887,337.94
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	77,812,276.13	9,321,599.85
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,130,410,676.00	3,511,830,455.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,840,056,900.00	3,187,954,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,840,056,900.00	3,187,954,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	290,353,776.00	323,875,855.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	167,646,428.00	135,222,112.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	35,000,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	87,707,348.00	188,653,743.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,568,429,633.02	5,426,179,415.09
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,568,429,633.02	5,426,179,415.09
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,746,486,545.54	4,788,838,548.37
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,102,684,649.76	2,681,333,108.50
210101	Үндсэн цалин	1,158,075,852.76	1,448,628,248.50
210102	Нэмэгдэл	247,009,092.00	316,433,194.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	338,205,944.00	354,032,000.00
210104	Урамшуулал	169,674,620.00	294,805,266.00
210105	Гэрээт ажлын хөлс	189,719,141.00	267,434,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	263,353,090.61	335,803,094.67
210201	Тэтгэврийн даатгал	186,661,709.70	235,164,156.69
210202	Тэтгэмжийн даатгал	20,120,716.45	27,202,647.03
210203	ҮОМШӨ-ний даатгал	15,551,900.93	20,916,916.93
210204	Ажилгүйдлийн даатгал	3,587,958.93	4,520,265.10
210205	Эрүүл мэндийн даатгал	37,430,804.60	47,999,108.92
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	358,407,966.00	388,877,100.00
210301	Гэрэл, цахилгаан	-	508,020.00
210304	Байрны түрээс	358,407,966.00	388,369,080.00
2104	Хангамж, бараа материалын зардал	137,652,261.27	189,641,063.09
210401	Бичиг хэрэг	47,267,790.50	64,392,548.77
210402	Тээвэр, шатахуун	40,223,419.00	49,659,341.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	25,958,791.27	30,878,139.70
210404	Ном, хэвлэл	-	852,110.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,545,320.00	12,662,503.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	19,398,540.50	31,196,420.62
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	1,258,400.00	-
2105	Нормативт зардал	142,673,341.00	193,503,539.86
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	121,723,791.00	168,763,710.86

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210502	Хоол, хүнс	11,634,550.00	24,739,829.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	9,315,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,600,700.00	27,514,920.00
210604	Урсгал засвар	7,600,700.00	27,514,920.00
2107	Томилолт, зочны зардал	64,998,600.00	68,583,750.00
210702	Дотоод албан томилолт	64,998,600.00	68,583,750.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	239,982,015.92	259,022,623.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	239,982,015.92	259,022,623.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	429,133,920.98	644,559,349.25
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	85,907,730.67	87,532,985.31
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	72,624,205.21	40,127,820.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	270,601,985.10	516,898,543.94
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	821,943,087.48	637,340,866.72
2132	Бусад урсгал шилжүүлэг	121,335,144.04	214,872,258.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	60,654,244.04	101,572,258.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	60,680,900.00	113,300,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	700,607,943.44	422,468,608.72
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	680,215,595.44	421,782,765.72
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	20,392,348.00	685,843.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	608,440,132.29	(275,378,446.40)
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,777,777.76	19,687,500.00
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	2,777,777.76	19,687,500.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	605,662,354.53	(295,065,946.40)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	4,395,185,884.92	5,052,607,330.90
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,260,530,900.92	1,528,111,575.90
120	Нийтлэг татварын бус орлого	1,260,530,900.92	1,528,111,575.90
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,260,530,900.92	1,528,111,575.90
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,260,530,900.92	1,528,111,575.90
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,134,654,984.00	3,524,495,755.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,840,056,900.00	3,187,954,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,840,056,900.00	3,187,954,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	294,598,084.00	336,541,155.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	167,144,736.00	135,842,412.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	39,746,000.00	12,045,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	87,707,348.00	188,653,743.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,384,769,184.92	4,974,377,630.90
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,384,769,184.92	4,974,377,630.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,550,160,797.44	4,267,036,764.18
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,141,418,965.26	2,677,443,929.00
210101	Үндсэн цалин	1,210,849,520.26	1,449,650,902.50
210102	Нэмэгдэл	184,060,916.00	315,874,452.08
210103	Унаа хоолны хөнгөлөлт	346,017,944.00	353,072,855.00
210104	Урамшуулал	179,564,482.00	294,745,538.00
210105	Гэрээт ажлын хөлс	220,926,103.00	264,100,181.42
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	265,551,874.11	339,692,274.17
210201	Тэтгэврийн даатгал	186,455,638.35	238,223,405.95
210202	Тэтгэмжийн даатгал	20,404,853.47	27,466,747.03
210203	ҮОМШӨ-ний даатгал	15,863,210.62	21,144,707.17
210204	Ажилгүйдлийн даатгал	3,808,691.27	4,524,905.10
210205	Эрүүл мэндийн даатгал	39,019,480.40	48,332,508.92
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	358,407,966.00	388,877,100.00
210301	Гэрэл, цахилгаан	-	508,020.00
210304	Байрны түрээс	358,407,966.00	388,369,080.00
2104	Хангамж, бараа материалын зардал	129,290,388.27	144,747,462.70
210401	Бичиг хэрэг	47,719,430.00	33,375,749.00
210402	Тээвэр, шатахуун	36,200,827.00	53,516,921.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	25,958,791.27	28,998,139.70
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,545,320.00	12,662,503.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,866,020.00	16,194,150.00
2105	Нормативт зардал	239,621,290.00	137,695,210.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	211,691,290.00	137,695,210.00
210502	Хоол, хүнс	13,215,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	14,715,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,195,400.00	17,404,540.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	88,000.00
210604	Урсгал засвар	8,195,400.00	17,316,540.00
2107	Томиллолт, зочны зардал	63,492,000.00	68,583,750.00
210702	Дотоод албан томиллолт	63,492,000.00	68,583,750.00

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	208,689,922.92	335,902,193.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	208,689,922.92	335,902,193.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	135,492,990.88	156,690,305.31
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	60,650,575.67	107,229,285.31
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	74,842,415.21	49,461,020.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	834,608,387.48	707,340,866.72
2132	Бусад урсгал шилжүүлэг	121,335,144.04	214,872,258.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3,480,900.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	60,654,244.04	101,572,258.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	57,200,000.00	113,300,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	713,273,243.44	492,468,608.72
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	680,215,595.44	421,782,765.72
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	33,057,648.00	70,685,843.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	10,416,700.00	78,229,700.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	10,416,700.00	78,229,700.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	10,416,700.00	78,229,700.00
2200	Дотоод эх үүсвэрээр	10,416,700.00	78,229,700.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	10,416,700.00	78,229,700.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(10,416,700.00)	(78,229,700.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (IX)=(VII)+(VIII)	0.00	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	998,650,312.74	998,650,312.74
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	998,650,312.74	998,650,312.74
9	Тайлант үеийн үр дүн	-	-	605,662,354.53	605,662,354.53
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	1,604,312,667.27	1,604,312,667.27
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	1,604,312,667.27	1,604,312,667.27
19	Тайлант үеийн үр дүн	-	-	(295,065,946.40)	(295,065,946.40)
20	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	1,309,246,720.87	1,309,246,720.87

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,370,348,600.00	4,294,283,410.18	76,065,189.82	98.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,370,348,600.00	4,294,283,410.18	76,065,189.82	98.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,255,734,100.00	4,185,411,152.18	70,322,947.82	98.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,648,857,800.00	2,646,873,208.50	1,984,591.50	99.9
210101	Үндсэн цалин	1,552,747,800.00	1,449,650,902.50	103,096,897.50	93.4
210102	Нэмэгдэл	374,889,700.00	313,633,913.00	61,255,787.00	83.7
210103	Унаа хоолны хөнгөлөлт	255,552,000.00	353,072,855.00	(97,520,855.00)	138.2
210104	Урамшуулал	205,668,300.00	294,745,538.00	(89,077,238.00)	143.3
210105	Гэрээт ажлын хөлс	260,000,000.00	235,770,000.00	24,230,000.00	90.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	372,607,200.00	335,803,094.67	36,804,105.33	90.1
210201	Тэтгэврийн даатгал	253,373,000.00	234,334,226.45	19,038,773.55	92.5
210202	Тэтгэмжийн даатгал	29,808,600.00	27,466,747.03	2,341,852.97	92.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	23,846,600.00	21,144,707.17	2,701,892.83	88.7
210204	Ажилгүйдлийн даатгал	5,962,000.00	4,524,905.10	1,437,094.90	75.9
210205	Эрүүл мэндийн даатгал	59,617,000.00	48,332,508.92	11,284,491.08	81.1
210301	Гэрэл, цахилгаан	508,000.00	508,020.00	(20.00)	100.0
210304	Байрны түрээс	388,369,100.00	388,369,080.00	20.00	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	132,054,800.00	122,945,321.70	9,109,478.30	93.1
210401	Бичиг хэрэг	29,025,300.00	29,135,220.00	(109,920.00)	100.4
210402	Тээвэр, шатахуун	45,246,200.00	36,055,309.00	9,190,891.00	79.7
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	29,016,900.00	28,998,139.70	18,760.30	99.9
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	12,672,200.00	12,662,503.00	9,697.00	99.9
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	16,094,200.00	16,094,150.00	50.00	100.0
2105	Нормативт зардал	182,351,900.00	179,160,210.00	3,191,690.00	98.2
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	182,351,900.00	179,160,210.00	3,191,690.00	98.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	50,214,800.00	50,209,240.00	5,560.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	32,893,000.00	32,892,700.00	300.00	100.0
210604	Урсгал засвар	17,321,800.00	17,316,540.00	5,260.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	58,419,000.00	45,219,750.00	13,199,250.00	77.4
210702	Дотоод албан томилолт	58,419,000.00	45,219,750.00	13,199,250.00	77.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	296,483,600.00	296,480,722.00	2,878.00	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	296,483,600.00	296,480,722.00	2,878.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	125,867,900.00	119,842,505.31	6,025,394.69	95.2
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	112,426,100.00	107,229,285.31	5,196,814.69	95.4

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,441,800.00	12,613,220.00	828,580.00	93.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	114,614,500.00	108,872,258.00	5,742,242.00	95.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	114,614,500.00	108,872,258.00	5,742,242.00	95.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	107,250,700.00	101,572,258.00	5,678,442.00	94.7
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,363,800.00	7,300,000.00	63,800.00	99.1
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,370,348,600.00	4,294,283,410.18	76,065,189.82	98.3
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,187,954,600.00	2,766,171,834.28	421,782,765.72	86.8
310001	Улсын төсвөөс санхүүжих	3,187,954,600.00	2,766,171,834.28	421,782,765.72	86.8
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,182,394,000.00	1,528,111,575.90	(345,717,575.90)	129.2
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,182,394,000.00	1,528,111,575.90	(345,717,575.90)	129.2
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	132	111	26	80.3
620001	Удирдах ажилтан	1	-	1	0.0
620002	Гүйцэтгэх ажилтан	93	75	18	80.6
620003	Үйлчлэх ажилтан	38	36	2	94.7

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон		/ төгрөгөөр /	
Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		336,541,155.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		336,541,155.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		159,855,312.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		30,570,720.50
210102	Нэмэгдэл		2,240,539.08
210105	Гэрээт ажлын хөлс		28,330,181.42
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		3,889,179.50
210201	Тэтгэврийн даатгал		3,889,179.50
2104	Хангамж, бараа материалын зардал		21,802,141.00
210401	Бичиг хэрэг		4,240,529.00
210402	Тээвэр, шатахуун		17,461,612.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		100,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		3,960,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		3,960,000.00
2107	Томилолт, зочны зардал		23,364,000.00
210702	Дотоод албан томилолт		23,364,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		39,421,471.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		39,421,471.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		36,847,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		36,847,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		176,685,843.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		106,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		106,000,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		70,685,843.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		70,685,843.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		336,541,155.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		336,541,155.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		135,842,412.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		12,045,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		188,653,743.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 311,049.0 мянган төгрөгийн 2 алдаа илэрснээс аудитын явцад 311,049.0 мянган төгрөгийн 2 алдааг залрууллаа

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн цаашид ашиглах боломжтой хөрөнгийг дахин үнэ тогтоож орлого авахдаа дахин үнэлгээний нөөцийг нэмэгдүүлж дансны бичилт буруу хийсэн	1	276,887.3					1	276,887.3				
Үр дүнгийн тайланд цалингийн зардлыг 1,357.7 мянга, дотоод албан томилолтын зардлыг 1,625.0 мянга, хоол хүнсний зардлыг 27,289.8 мянган төгрөгөөр тус тус илүү, НДШ-ийн зардлыг 3,889.2 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан	1	34,161.7					1	34,161.7				
Дүн	2	311,049.0					2	311,049.0				

Аудитаар нийт 302,127.3 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 278,112.9 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 24,014.4 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Үүнээс				
		Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж	Хариуцлага тооцуулах албан шаардлага	Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газрын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Удирдах албан тушаалтны буруу шийдвэрээр ажлаас халагдсан албан тушаалтанд шүүхийн шийдвэрийн дагуу төсвөөс олгосон цалингийн олговрыг буруутай албан тушаалтнаар төлүүлээгүй	1	18,980.4					1	18,980.4				
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг, ажил үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлын төсвөөс урсгал засварын зардалд 163,298.8 мянга, бичиг хэргийн зардалд 11,240.0 мянга, шуудан, холбоо интернэтийн зардалд 1,880.0 мянга, бусад зардал цайны зардалд 4,043.0 мянга, нийт 180,461.8 мянган төгрөгийг зардлын ангилал зөрчин зориулалт бусаар зарцуулсан	1	180,461.8			1	180,461.8						
Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл худалдан авахдаа харьцуулалтын аргаас зайлсхийж, 62,830.1 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээг шууд худалдан авалт хийсэн	1	62,830.1			1	62,830.1						
ЭЭХХЗГ-ын даргын 2023 оны 12 дугаар сарын 21- ний өдрийн А/264 дугаар тушаалаар нийт албан хаагчдад урамшуулал олгоод 25,440.0 мянган төгрөгийн НДШ, 9,381.0 мянган төгрөгийн ХХОАТ суутган тооцоогүй.	1	34,821.0			1	34,821.0						
Машин тоног төхөөрөмжийн дансанд 4,991.5 мянган төгрөгийн бусад хангамжийн материал, Тавилга аж ахуйн эд хогшлын дансанд 42.5 мянган төгрөгийн бусад хангамжийн материалыг буруу ангилан бүртгэсэн	1	5,034.0					1	5,034.0				
Дүн	5	302,173.3			3	278,112.9	2	24,014.4				

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 18,424.5 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 18,424.5 мянган төгрөгийн албан шаардлага өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Эм эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газар нь тайлант онд шилэн дансны цахим системд 18,424.5 мянган төгрөгийн 2 зарлагын гүйлгээний мэдээллийг шилэн дансны цахим системд байршуулаагүй байна.	1	18,424.5	1	18,424.5		
Дүн	1	18,424.5	1	18,424.5		